



# Монгол дахь Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төв Үндэслэгч Түвдэн Ешэ ламтан, Номын удирдагч Түвдэн Зона Ринбүүчи

Foundation for the Preservation of Mahayana Tradition in Mongolia  
Lama Thubten Yeshe, Founder; Lama Zopa Rinpoche, Spiritual Director

20 . . . оны . . . сарын . . . өдөр

Дугаар . . .

Улаанбаатар хот

## ИХУХТөвийн Ёс зүйн Бодлого

1. **Эглийн Таван сахил:** Таван сахил нь ИХУХТ-ийн өмнөөс болон Төвд холбогдох аливаа үүрэг, хариуцлага эсвэл үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа болон гүйцэтгэхээр зорьж буй бүх хүмүүсийн ёс зүйн үндэс суурь болдог. Таван үндсэн сахилд амь таслахгүй, хулгай хийхгүй, зохисгүй бэлгийн харьцаанд орохгүй эсвэл холбогдохгүй, худал хэлэхгүй, хорт бодис хэрэглэхгүй байх явдал эдгээр юм. Хорт бодис гэдэгт согтууруулах ундаа, мансууруулах бодис болон тамхины төрлийн бүтээгдэхүүн орно.
2. **Ялгаварлан гадуурхахгүй байх :** ИХУХ байгууллага нь хөтөлбөр, үйлчилгээ, ажил эрхлэлт, сайн дурын ажил болон бусад үйл ажиллагаандаа арьс өнгө, үндэс угсаа, хүйс, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн байдал, нас, хөгжлийн бэрхшээлээс хамааран ялгаварлан гадуурхаж болохгүй.
3. **Дарамт шахалтгүй байх:** ИХУХТөв нь хүн нэг бүрийн нэр төрийг хүндэтгэн үздэг аюулгүй орчин бүрдүүлэх үүрэг хүлээдэг. ИХУХТ-тэй холбоотой үйл ажиллагаанд оролцсон хүн бүр бэлгийн дарамт, айлган сүрдүүлэх, дээрэлхэх болон бусад дарамт шахалт зэргээс үл хамааран ямар ч төрлийн дарамт шахалтаас ангид байх эрхтэй. ИХУХТ –тэй харьцаж буй хүн бүртэй нэр төртэй, хүндэтгэлтэй хандах ёстой.

#### 4. Дотнын харилцаа

Шавь багшаас сургаал ном сонсож буй болон хөтөлж буй бясалгал бүтээлд сууж буй бол Номын багш болон шавийн хоорондын бэлгийн харилцааг хориглоно, мөн багш шавийн харилцаа тасраагүй л бол энэ адилаар харилцааг тэвчих нь зүйтэй. Номын багш нарт зориулсан бодлогыг тусад нь дор орууллаа. Мөн эрх мэдэл бүхий албан тушаал хашиж буй хүмүүс эрх мэдлийн бодитой бөгөөд төсөөлөгдөж буй тэнцвэргүй байдлын үед бэлгийн харьцаанд орохоос зайлсхийх нь зүйтэй. Түүнчлэн багш, сайн дурын ажилтан, ажилтнууд, төвийг төлөөлөлж буй хэн ч байсан сургалт, хичээл эсвэл ном бүтээлийн үеэр аливаа оролцогчдод бэлгийн хандлага гаргахыг хориглоно.

5. **Зөв хэл яриа :** Эрх мэдэл бүхий албан тушаал хашиж байгаа хүмүүс хов жив, хатуу ширүүн үг хэллэгээс зайлсхийх ёстой, учир нь бусад хүмүүсийг үл ойшоож буй яриа нь ИХУХТийн үйл ажиллагаанд хамрагдаж буй хүмүүст сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Хатуу ширүүн үг яриа нь дайрч доромжлох, дээрэлхэх байдлыг бүрэлдүүлнэ.
6. **Санхүү :** ИХУХТ-ийн салбаруудын орлого, зарлагыг нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох зарчмуудын дагуу тооцох ёстой. Тодорхой төсөлд хандивласан мөнгийг үйл ажиллагааны зардал болон бусад төсөлд зарцуулахгүй зөвхөн тухайн төсөлд зарцуулах ёстой. Шашны эдлэл борлуулж олсон орлогыг үйл ажиллагааны зардалд бус шашны зорилгоор ашиглах ёстой.
7. **Мэдээлэгчийн хамгаалалт :** Хэрэв хувь хүн эсвэл бүлэг хүмүүс нь ИХУХТ байгууллагын үйл ажиллагааг хууль бус эсвэл энэ нь Ёс зүйн бодлогын эсрэг гэж үзэж, холбогдох удирдлагад хандаж байгаа бол тухайн хувь хүн, бүлэг нь хариу шийтгэл авахаас хамгаалагдсан байх ёстой.

*ИХУХТ-д бүртгэлтэй багш, хичээлийн ахлагч, орчуулагч нарт зориулсан нэмэлт бодлого.*



Жуулчны гудамж 34/1 Барилгачдын талбай; Монгол Улс, Улаанбаатар 13 Ш/х 219  
Juulchnii Gudamj 34/1/ Barilgachdyn Talbai; PO Box 219, Ulaanbaatar 13, Mongolia  
Tel: +976 (11) 321 580; [info@fpmtmongolia.org](mailto:info@fpmtmongolia.org)  
[www.fpmtmongolia.org](http://www.fpmtmongolia.org)



# Монгол дахь Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төв Үндэслэгч Түвдэн Ешэ ламтан, Номын удирдагч Түвдэн Зона Ринбүүчи

Foundation for the Preservation of Mahayana Tradition in Mongolia  
Lama Thubten Yeshe, Founder; Lama Zopa Rinpoche, Spiritual Director

20 . . . оны . . . сарын . . . өдөр

Дугаар . . .

Улаанбаатар хот

Багш шавийн харилцааны онцлог байдлаас үүдэн ИХУХТ-д бүртгэлтэй багш, хэлмэрч, анхан шатны хичээлийн ахлагчид нь дараах нэмэлт бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай.

## Нууцлалыг хадгалах :

Тодорхой мэдээллийг задруулахыг хуульд зааснаас бусад тохиолдолд шавь нарын зөвшөөрөлгүйгээр үүнд зөвхөн хувийн ярилцлагаар хязгаарлагдах бус, нууцлалыг хадгална хэмээх итгэлээр ямар ч нөхцөл байдалд хамаагүй шавь нарын задруулсан бүхнийг багш, хэлмэрч, хичээлийн ахлагч нар нь мэдээллийн нууцыг хүндэтгэж шавь нараас ирсэн бүх харилцан яриаг нууцалж байх ёстой.

- **Шударга байдал:** Номын багш нар болон ангийн удирдагчид өөрсдийн эрдэм чадлын талаар үнэнч шударга байх ёстой бөгөөд тэдний эрдэм чадлын талаархи буруу мэдээлэл гарч ирмэгц засч залруулах ёстой.

- **Зохисгүй харилцаанаас зайлсхийх:** Номын багш нар, хичээлийн ахлагчийн сургалт, номын айлдвар, бүтээл бясалгалд хамрагдах үеэр шавьтай бэлгийн харьцаанд орохгүй байх болон сонирхолтой байгаагаа илэрхийлэх ёсгүй. Номын багш нар болон хичээлийн удирдагч нар нь эрх мэдэлээ ашиглан хичээл, сургалт эсвэл номын бүтээлд оролцож буй оюутнууд, сайн дурынхан эсвэл бусад оролцогчидод бэлгийн харьцаанд орох, санаачлах зэргээр байр сууриа хэзээ ч ашиглах ёсгүй.



Жуулчны гудамж 34/1 Барилгачдын талбай; Монгол Улс, Улаанбаатар 13 Ш/х 219  
Juulchnii Gudamj 34/1/ Barilgachdyn Talbai; PO Box 219, Ulaanbaatar 13, Mongolia  
Tel: +976 (11) 321 580; [info@fpmtmongolia.org](mailto:info@fpmtmongolia.org)  
[www.fpmtmongolia.org](http://www.fpmtmongolia.org)